

# ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Чандмань-Өндөр сумын ТТЗ-ийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2023/02/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Хөвсгөл аймаг  
2023 он

Дарга, тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар

Утас: 88883317 Цахим хаяг:  
erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр

Утас: 99089114 Цахим хаяг:  
tegshdelgerb@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Давааням

Утас: 92113932 Цахим хаяг:  
davaanyamb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт .....	4-5
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	6-9
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....	10
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа .....	10
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин .....	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	10-11
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт .....	11-12
3.5 Төсвийн төлөвлөлт гүйцэтгэл.....	12-15
4. Аудитын тайлан .....	16
4.1 Ерөнхий зүйл .....	16
4.2 Материаллаг байдал .....	16
4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	17
5. Аудитын илрүүлэлт .....	17
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....	18-19

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн Өмчийн Бодлого Зохицуулалтын Газар
ТТЗ	Төсийн Төвлөрүүлэн Захирагч
ОНХС	Орон Нутгийн Хөгжлийн Сан



ЧАНДМАНЬ-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ  
ДАРГА Л.ЭНХЖАРГАЛ ТАНАА

## ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,  
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120  
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

2023.03.22 № 01/278  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

### Хараат бус аудиторын дүгнэлт

#### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Чандмань-Өндөр сумын ТТЗ-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Чандмань-Өндөр сумын ТТЗ-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд тус төвлөрүүлэн захирагчийн харьяаны байгууллагуудаас Хүүхдийн цэцэрлэг, Ерөнхий боловсролын сургууль, Эрүүл мэндийн төв, Соёлын төв гэсэн 4 байгууллага улсын төсөвт шилжсэн байна.

#### Аудитын гол асуудал

Чандмань-Өндөр сумын Хоршоо хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлтэй 20 иргэнтэй холбоотой 88.4 сая төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байна.

#### Бусад асуудлын хэсэг

Чандмань-Өндөр сумын Засаг дарга нь аймгийн Засаг даргатай 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө байгуулж, хэрэгжилтийг 92.3 хувьтай биелүүлж ажилласан байна.

#### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт

олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  А.ЭРДЭНЭБААТАР



## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	/Мянган төгрөгөөр/	
		2021оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,090,488.4	754,538.6
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	368,843.1	524,486.4
33	АВЛАГА	135,950.1	88,357.5
35	БАРАА МАТЕРИАЛ	585,695.3	141,694.8
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	4,542,967.9	1,102,893.4
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	66,815.8	28,296.3
37300	Урт хугацаат зээл	66,815.8	28,296.3
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	4,476,152.1	1,074,597.1
39200	Биет хөрөнгө	4,293,880.4	988,485.4
39300	Биет бус хөрөнгө	182,271.7	86,111.7
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	5,633,456.3	1,857,432.0
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	5,633,456.3	1,857,432.0
51	Засгийн газрын хувь оролцоо	5,633,456.3	1,857,432.0
51100	Засгийн газрын оруулсан капитал	2,078,151.5	330,172.4
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	2,078,151.5	330,172.4
51200	Хуримтлагдсан үр дүн	3,124,615.0	1,215,799.6
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	430,689.8	311,460.0
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	5,633,456.3	1,857,432.0

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	/Мянган төгрөгөөр/	
		2021оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	4,657,756.5	1,459,485.4
11	ТАТВАРЫН ОРЛОГО	304,883.8	627,561.3
110	Орлогын албан татвар	30,770.0	170,145.2
1100	Хувь хүний орлогын албан татвар	30,770.0	182,774.1
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	0.0	-12,628.9
113	Хөрөнгийн албан татвар	16,111.7	41,899.0
118	Бусад татвар, төлбөр, хураамж	258,002.1	415,517.2
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,495,175.9	269,360.1
120	Нийтлэг татварын бус орлого	1,480,675.9	266,460.1
121	Хөрөнгийн орлого	14,500.0	2,900.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,857,696.7	562,564.1
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3,250,636.6	1,006,076.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,250,636.6	1,006,076.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,115,945.3	949,218.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,896,869.8	422,178.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	245,803.1	53,407.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	121,976.5	140,396.2
2104	Хангамж, бараа материалын зардал	108,998.3	36,456.8
2105	Нормативт зардал	331,198.1	0.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	109,979.4	106,619.6
2107	Томилолт, зочны зардал	7,554.8	4,796.9
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	18,431.5	27,830.6
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	275,133.6	157,533.1
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	134,691.4	56,857.8
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	1,407,119.8	453,408.9
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	22,837.5	4,187,261.2
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	1,384,282.3	-3,733,852.3

**Хөвсгөл аймгийн Чандмань-Өндөр сумын ТТЗ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан**

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

		/Мянган төгрөгөөр/	
Код:	Тайлангийн үзүүлэлт	2021оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	3,256,457.2	1,253,088.3
11	ТАТВАРЫН ОРЛОГО	304,883.8	627,561.3
110	Орлогын албан татвар	30,770.0	170,145.2
1100	Хувь хүний орлогын албан татвар	30,770.0	182,774.1
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	0.0	-12,628.9
113	Хөрөнгийн албан татвар	16,111.7	41,899.0
118	Бусад татвар, төлбөр, хураамж	258,002.1	415,517.2
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	12,313.5	18,259.3
1181	Газрын төлбөр	5,362.2	16,336.7
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	240,326.5	380,921.2
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	126,111.1	62,963.0
120	Нийтлэг татварын бус орлого	111,611.1	60,063.0
121	Хөрөнгийн орлого	14,500.0	2,900.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,825,462.2	562,564.1
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,771,594.4	1,084,445.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,771,594.4	1,084,445.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,636,903.0	783,270.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,898,481.7	422,158.3
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	245,635.8	53,312.7
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	118,253.5	143,487.4
2104	Хангамж, бараа материалын зардал	82,462.3	26,596.2
2105	Нормативт зардал	178,772.6	0.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	31,217.5	27,013.6
2107	Томиллолт, зочны зардал	7,554.8	4,796.9
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	18,740.8	35,370.5
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	55,784.0	70,534.6
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	134,691.4	301,174.8
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	484,862.8	168,643.3
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	240,100.9	13,000.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	240,100.9	13,000.0
2200	Дотоод эх үүсвэрээр	240,100.9	13,000.0
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-240,100.9	-13,000.0
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-53,000.0	0.0
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	53,000.0	0.0
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	191,761.9	155,643.3
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	177,081.2	368,843.1
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	368,843.1	524,486.4

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

		/Мянган төгрөгөөр/		
Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,249,174.0	0.0	4,249,174.0
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	7,342.9	0.0	7,342.9
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,256,516.9	0.0	4,256,516.9
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-7,342.9	0.0	-7,342.9
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.0	0.0	0.0

**Хөвсгөл аймгийн Чандмань-Өндөр сумын ТТЗ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан**

6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.0	0.0	0.0
7	Өмчид гарсан өөрчилөлт	0.0	0.0	0.0
8	Зарласан ногдол ашиг	0.0	0.0	0.0
9	Тайлант үеийн үр дүн	1,384,282.3	0.0	1,384,282.3
10	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,633,456.3	0.0	5,633,456.3
11	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	5,633,456.3	0.0	5,633,456.3
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-42,171.9	0.0	-42,171.9
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	5,591,284.4	0.0	5,591,284.4
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.0	0.0	0.0
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.0	0.0	0.0
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.0	0.0	0.0
17	Өмчид гарсан өөрчилөлт	0.0	0.0	0.0
18	Зарласан ногдол ашиг	0.0	0.0	0.0
19	Тайлант үеийн үр дүн	-3,733,852.3	0.0	-3,733,852.3
20	2022 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	1,857,432.0	0.0	1,857,432.0

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

/Мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,327,987.0	1,073,141.9	254,845.1	80.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,218,487.0	1,073,141.9	145,345.1	88.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	859,506.6	792,815.2	66,691.4	92.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	437,457.7	422,158.3	15,299.4	96.5
210101	Үндсэн цалин	419,242.2	343,883.1	75,359.1	82.0
210102	Нэмэгдэл	14,495.5	51,305.1	-36,809.6	353.9
210104	Урамшуулал	3,720.0	26,970.2	-23,250.2	725.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	62,545.4	53,312.7	9,232.7	85.2
210201	Тэтгэврийн даатгал	43,894.9	36,374.7	7,520.2	82.9
210202	Тэтгэмжийн даатгал	5,648.6	4,253.8	1,394.8	75.3
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,467.2	3,389.9	77.3	97.8
210204	Ажилгүйдлийн даатгал	866.8	844.2	22.6	97.4
210205	Эрүүл мэндийн даатгал	8,667.9	8,450.2	217.7	97.5
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	145,550.0	143,487.4	2,062.6	98.6
210301	Гэрэл, цахилгаан	30,000.0	34,364.3	-4,364.3	114.5
210302	Түлш, халаалт	108,500.0	107,620.0	880.0	99.2
210303	Цэвэр, бохир ус	7,050.0	1,503.1	5,546.9	21.3
2104	Хангамж, бараа материалын зардал	26,606.5	26,596.2	10.3	100.0
210401	Бичиг хэрэг	2,900.0	3,171.9	-271.9	109.4
210402	Тээвэр, шатахуун	18,576.5	18,564.8	11.8	99.9
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,180.0	3,234.2	-54.2	101.7
210404	Ном, хэвлэл	350.0	0.0	350.0	0.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,600.0	1,625.4	-25.4	101.6
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	35,745.5	29,713.6	6,032.0	83.1
210601	Багаж, техник, хэрэгсэл	8,700.0	2,700.0	6,000.0	31.0
210604	Урсгал засвар	27,045.5	27,013.6	32.0	99.9
2107	Томилот, зочны зардал	4,800.0	4,796.9	3.1	99.9
210702	Дотоод албан томилолт	4,800.0	4,796.9	3.1	99.9
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	53,986.7	41,560.5	12,426.2	77.0

**Хөвсгөл аймгийн Чандмань-Өндөр сумын ТТЗ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан**

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	51,508.7	39,198.1	12,310.6	76.1
210803	Даатгалын үйлчилгээ	238.0	188.9	49.1	79.4
210804	Тээврийн хэрэгслийн татвар	120.0	113.5	6.5	94.6
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	55.0	55.0	0.0	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	500.0	440.0	60.0	88.0
210807	Газрын төлбөр	1,565.0	1,565.0	0.0	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	92,814.8	71,189.7	21,625.2	76.7
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	81,814.8	60,421.9	21,392.9	73.9
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	11,000.0	10,767.8	232.3	97.9
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	358,980.4	280,326.7	78,653.7	78.1
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	320,304.0	241,650.3	78,653.7	75.4
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	320,304.0	241,650.3	78,653.7	75.4
2132	Бусад урсгал шилжүүлэг	38,676.4	38,676.4	0.0	100.0
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	24,176.4	24,176.4	0.0	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	14,500.0	14,500.0	0.0	100.0
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	109,500.0	0.0	109,500.0	0.0
230001	Эргэж төлөгдөх зээл	109,500.0	0.0	109,500.0	0.0
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,327,987.0	1,176,001.1	151,985.9	88.6
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	140,068.9	140,068.9	0.0	100.0
310004	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	140,068.9	140,068.9	0.0	100.0
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	796,113.6	982,744.9	-186,631.3	123.4
320001	Орон нутгийн төсвөөс	796,113.6	982,744.9	-186,631.3	123.4
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	391,804.5	53,187.3	338,617.2	13.6
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	50,999.9	50,761.5	238.4	99.5
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,500.0	2,425.8	-925.8	161.7
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	339,304.6	0.0	339,304.6	
4	Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл		138,221.1	138,221.1	
5	Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл		178,438.4	178,438.4	

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

/Мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,490,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,490,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,455,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,910,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,910,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	545,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	545,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	35,000.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	35,000.00
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	35,000.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,490,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	3,490,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,210,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	280,000.00
	Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл	
	Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл	

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

**Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар:** Чандмань-Өндөр сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь стратегийн төлөвлөгөө, бодлогын удирдамжийн хэрэгжилт, хөтөлбөр, төслийн биелэлт зэргийг Засаг даргын дэргэдэх тасаг, алба, албан байгууллага, аж ахуйн нэгжид хэрхэн хэрэгжиж байгааг хянах, шалгах, зохицуулах, чиглэл өгөх, мэдээлэл авах зэрэг эрхтэйгээс гадна дээрх байгууллагаар дамжуулан мэдээллийг цуглуулж хяналт шинжилгээ хийх дүгнэлт гаргах үүрэгтэй ажилладаг орон нутгийн төсвийн захирагч юм.

Чандмань-Өндөр сумын төсвийн төвлөрүүлэн захирагч нь тайлант хугацаанд “Олон нийтийн оролцоонд тулгуурласан, ил тод хариуцлагатай засаглалтай иргэдээ дээдэлсэн төрийн үйлчилгээг эрхэмлэн, сумын хөгжил дэвшлийг оновчтой бодлогоор хангана” гэсэн эрхэм зорилго дэвшүүлэн ажилласан байна

Чандмань-Өндөр сумын Засаг дарга нь аймгийн Засаг даргатай 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө байгуулж, хэрэгжилтийг 92.3 хувьтай биелүүлж ажилласан байна.

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

**Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар:** Тус байгууллага нь Төсвийн тухай хууль, Засаг захиргаа нутаг дэвсгэрийн удирдлагын тухай хууль, Татварын багц хууль болон бусад хууль тогтоомж, журам зааврыг мөрдөн ажилласан байна. Тайлант онд Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжсэнтэй холбоотой харьяа байгууллагуудын үйл ажиллагаанд хэмнэлтийн горимыг хэрэгжүүлэх хяналтыг тавьж ажилласан байна.

Тус төвлөрүүлэн захирагчийн харьяаны байгууллагуудаас Засгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 403 дугаар тогтоолоор Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Боловсролын ерөнхий газрыг байгуулж, 2022 оны 131 дүгээр тогтоолоор Боловсролын ерөнхий газрын даргыг Сургуулийн өмнөх болон бага, дунд, мэргэжлийн, техникийн боловсролын сургалтын байгууллагуудын төсвийн төвлөрүүлэн захирагчаар баталсан тул Хүүхдийн цэцэрлэг, Ерөнхий боловсролын сургууль улсын төсөвт, Соёлын төв болон Эрүүл мэндийн төв нь Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлд орсон нэмэлт өөрчлөлтийн дагуу тус тус улсын төсөвт шилжсэн байна

**Байгууллагын дотоод хяналтын талаар:** Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-ийн дагуу Засаг даргын 2020 оны 04 сарын 13 өдрийн А/55 тоот захирамжаар 5 хүний бүрэлдэхүүнтэй дотоод хяналтын баг байгуулсан байна.

Дотоод хяналтын ажлын хэсэг нь 2022 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө батлуулан харьяа байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаа, ОНХС-ийн үйл ажиллагаа, өмч хөрөнгийн бүртгэл, ашиглалт, орон нутгийн орлогын гүйцэтгэл, шилэн дансны мэдээлэл зэрэг үйл ажиллагаанд дотоод хяналтыг хэрэгжүүлсэн байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэн, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааг зохион байгуулж ажилласан хэдий ч үр дүнг тооцож илэрсэн зөрчлийг арилгасан эсэхэд хяналт тавьж ажиллаагүй байна.

Тайлант онд дээд шатны төсвийн захирагчийн дотоод аудитын чиг үүрэг хэрэгжүүлэх нэгжээс хяналтыг хэрэгжүүлээгүй байна.

#### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Чандмань-Өндөр сумын ТТЗ-ийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан иж бүрдийн дагуу бэлтгэж толилуулсан байна гэж үзлээ.

Харин төсвийн гүйцэтгэлийн тайланг мөнгөн сууриар бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 дахь заалтад заасан заалтын дагуу иж бүрэн ирүүлсэн.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Чандмань-Өндөр ТТЗ-ийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2005 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Санхүүгийн нэгтгэсэн тайлан гаргах зааврын”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 3,776.1 сая төгрөгөөр буурсан байна.

#### Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	368.8	524.5	155.7
Авлага	136.0	88.4	-47.6
Бараа материал	585.7	141.7	-444
Үндсэн хөрөнгө	4,476.2	1,074.6	-3,401.6
Нийт хөрөнгө	<b>5,633.5</b>	<b>1,857.4</b>	<b>-3,776.1</b>
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	5,633.5	1,857.4	-3,776.1
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	<b>5,633.5</b>	<b>1,857.4</b>	<b>-3,776.1</b>

Дээрх хүснэгтээс харахад мөнгөн хөрөнгийн үлдэгдэл нэмэгдэж бараа материал, үндсэн хөрөнгө, авлагын дансны үлдэгдлүүд буурсан үзүүлэлттэй байна. Үүнд:

- Авлагын үлдэгдэлд Хоршоо хөгжүүлэх сангийн зээл, зээлийн хүүгийн 88.4 сая төгрөгийн авлагатай байна.

Хоршоо хөгжүүлэх сангийн өмнөх оны үлдэгдлээс 50.7 сая төгрөгийн авлага барагдсан байна. Хоршоо хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлтэй 20 иргэнтэй холбоотой 88.4 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Энэ нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны 361 дүгээр тушаалаар баталсан "Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам"-ын 3.2.1."орон нутгийн жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх тэргүүлэх чиглэлийг жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ, хоршоо хөгжүүлэх бодлоготой уялдуулан тогтоож, хэрэгжилтийг зохион байгуулах, биелэлтэд нь хяналт тавих" гэсэн заалттай нийцэхгүй байна.

- Бараа материалын дансны үлдэгдэл буурахад Ерөнхий боловсролын сургууль, Хүүхдийн цэцэрлэг, Соёлын төв, Эрүүл мэндийн төв гэсэн 4 байгууллага улсын төсөвт шилжсэнээр нийт 500.5 сая төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүй бүтцийн өөрчлөлтөөр шилжүүлсэн нь нөлөөлсөн байна. Үүнд: Ерөнхий боловсролын сургууль 310.2 сая төгрөг, хүүхдийн цэцэрлэг 74.2 сая төгрөг, Соёлын төв 37.0 сая төгрөг, Эрүүл мэндийн төв 79.0 сая төгрөгийн бараа материалыг тус тус шилжүүлсэн байна.
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл буурахад Ерөнхий боловсролын сургуулийн 1,798.7 сая төгрөг, хүүхдийн цэцэрлэг 1,080.3 сая төгрөг, Соёлын төв 161.9 сая төгрөг, Эрүүл мэндийн төв 639.6 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг бүтцийн өөрчлөлтөөр улсын төсөвт шилжүүлсэн нь нөлөөлсөн байна.

#### Орлогын данс

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангаар нийт 1,459.5 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж тайлагнасан байна. Тайлант онд бүрдүүлсэн орлогыг өмнөх онтой харьцуулахад 3,198.3 сая төгрөгөөр буюу 31.3 хувиар буурсан байна.

Хүснэгт №2 Санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт орлого

/сая төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	зөрүү	Хувь
Татварын орлого	304.9	627.6	322.7	205.8
Татварын бус орлого	1,495.2	269.4	-1,225.8	18.0
Тусламж санхүүжилтийн орлого	2,857.7	562.6	-2,295.1	19.7
<b>Нийт дүн</b>	<b>4,657.8</b>	<b>1,459.5</b>	<b>-3,198.3</b>	<b>31.3</b>

Нийт орлогын дүн буурсан шалтгаан нь боловсрол, соёл, эрүүл мэндийн байгууллагууд улсын төсөвт шилжиж улсын төсвөөс авах санхүүжилт хасагдсанаас шалтгаалсан байна.

Санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайланд харьяа байгууллагуудын 1,202.2 сая төгрөгийн орлогын давхардсан 15 гүйлгээ, мөнгөн гүйлгээний тайланд 1,045.4 сая төгрөгийн орлогын давхардсан 13 гүйлгээг устгаж цэвэр дүнгээр тайлагнасан байна.

**Зардлын данс**

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлангаар 3,273.4 сая төгрөгийн зардал гаргасан байна.

Хүснэгт №3: Санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардал

/сая төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	зөрүү	Хувь
Бараа ажил үйлчилгээний зардал	3,115.9	949.2	-2,166.7	30.5
Урсгал шилжүүлэг	134.7	56.9	-77.8	42.2
<b>Үйл ажиллагааны зардлын дүн</b>	<b>3,250.6</b>	<b>1,006.1</b>	<b>-2,244.5</b>	<b>31.0</b>

Эх сурвалж: Чандмань-Өндөр төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

Нийт зардлын дүн буурсан нь Ерөнхий боловсролын сургууль, Хүүхдийн цэцэрлэг, Соёлын төв, Эрүүл мэндийн төв гэсэн 4 байгууллага улсын төсөвт шилжиж орон нутгаас байр ашиглалтын зардлыг санхүүжүүлэх болсноор төсвийн зардал 31.0 хувиар буурахад гол нөлөө үзүүлсэн байна.

Санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайланд харьяа байгууллагуудын 1,202.2 сая төгрөгийн зарлагын давхардсан 15 гүйлгээ, мөнгөн гүйлгээний тайланд 1,045.4 сая төгрөгийн зарлагын давхардсан 13 гүйлгээг устгаж цэвэр дүнгээр тайлагнасан байна.

**3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны төсвийн төслийг харьяа байгууллагуудын хүрээнд нэгтгэн боловсруулж дээд шатны төсөв захирагчид хүргүүлсэн байна.

Чандмань-Өндөр сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 11 хөтөлбөрт зориулан 1,434.7 сая төгрөгийн төсөв баталснаас 965.3 сая төгрөгийг бараа үйлчилгээний зардалд, урсгал шилжүүлгийн зардалд 358.9 сая төгрөгийг, Эргэж төлөгдөх зээлийн зардалд 110.5 сая төгрөгийг зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 163.6 сая төгрөгийг орон нутгийн хөгжлийн сангаас, санхүүгийн дэмжлэгээс 566.9 сая төгрөгийг, сумын орон нутгийн орлогоос 377.1 сая төгрөгийг, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос 111.6 сая төгрөгийг, давсан орлого дансны үлдэгдлээс 215.5 сая төгрөгийг тус тус санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Тайлант онд Чандмань-Өндөр сумын ИТХ-ын 2023 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн 05 дугаар тогтоолоор төсөвт 89.0 сая төгрөгийн хасах тодотгол хийж төсвийг 1,327.9 сая төгрөгөөр баталсан байна.

**3.6.2 Төсвийн орлогын гүйцэтгэл**

Гүйцэтгэлээр Төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос 53.2 сая төгрөгийг, Санхүүгийн дэмжлэгээс 419.0 сая төгрөгийг, орон нутгийн төсвөөс 377.1 сая төгрөгийг, орон нутгийн хөгжлийн

**Хөвсгөл аймгийн Чандмань-Өндөр сумын ТТЗ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан**

сангаас 140.0 сая төгрөгийг, давсан орлого дансны үлдэгдлээс 186.6 сая төгрөгийг нийт 1,176.0 сая төгрөгийн орлогыг бүрдүүлсэн байна.

**Сумын төсвийн орлого бүрдүүлэлт.**

Чандмань-Өндөр сумын ИТХ-ын 2022 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн 05 дугаар тогтоолд зааснаар Чандмань-Өндөр сумын төсвийн төвлөрүүлэн захирагч нь тайлант онд 377.1 сая төгрөгийн орлогыг сумын орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр баталсан байна. Гүйцэтгэлээр 637.3 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 169.0 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт №3. Төвлөрүүлэх орлого

/сая төгрөг/

ҮЗҮҮЛЭЛТ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>Татварын орлого</b>	<b>373.3</b>	<b>627.6</b>	<b>254.3</b>	<b>168.1</b>
Хувь хүний орлогын албан татвар	149.8	170.1	20.3	113.6
цалин хөлс шагнал урамшил	135.0	159.0	24.0	117.7
Үйл ажиллагааны орлого	8.9	2.5	-6.4	27.8
Хөрөнгийн орлого	22.0	15.29	-6.7	69.5
Хөрөнгө борлуулсны орлого	0.5	0.2	-0.3	44.6
Шууд бус орлого	8.9	5.8	-3.1	65.4
ХХОАТ-ын буцаан олголт	-25.5	-12.6	-12.9	49.5
үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	10.0	15.2	5.2	151.6
Бууны албан татвар	3.2	3.3	0.1	102.2
Малд ногдуулах албан татвар	25.0	23.5	-1.5	93.9
Улсын тэмдэгтийн хураамж	4.8	14.8	10.0	308.7
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	1.0	0.0	-1.0	0.0
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	4.3	3.44	-0.9	79.2
Газрын төлбөр	11.5	16.3	4.8	142.1
Газрын төлбөр	10.5	14.0	3.5	133.4
Дуудлага худалдаа	1.0	2.3	1.3	233.4
Ойн нөөц ашигласны төлбөр	159.0	377.51	218.5	237.4
Ан амьтны нөөц ашигласны төлбөр	2.1	1.0	-1.1	46.2
Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	1.0	0.7	-0.3	68.9
Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр	1.5	1.7	0.2	116.0
<b>Татварын бус орлого</b>	<b>3.8</b>	<b>9.8</b>	<b>6.0</b>	<b>257.3</b>
Хувьцааны ногдол ашиг	0.0	0.0	0.0	
Торгуулийн орлого	3.8	6.9	3.1	180.9
Түрээсийн орлого	0.0	0.0	0.0	
Бусад орлого	0.0	0.0	0.0	
Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгө борлуулсны орлого	0.0	2.9	2.9	
<b>ОРОН НУТГИЙН ОРЛОГО</b>	<b>377.1</b>	<b>637.3</b>	<b>260.2</b>	<b>169.0</b>

Эх сурвалж: Чандмань-Өндөр төсвийн төвлөрүүлэн захирагчийн төсвийн гүйцэтгэлийн танилцуулга

Чандмань-Өндөр сумын орон нутгийн орлого 260.2 сая төгрөгөөр давж биелэхэд Цалин хөлс шагнал урамшууллын орлого 24.0 сая төгрөгөөр, хувь хүний орлогын албан татварын орлого 20.3 сая төгрөгөөр, Ойн нөөц ашигласны төлбөрийн орлого 218.5 сая төгрөгөөр давж биелсэн нь нөлөөлсөн байна.

Орон нутгийн орлогыг нэр төрлөөр нь авч үзвэл:

Үйл ажиллагааны орлого 6.4 сая төгрөгөөр, хөрөнгийн орлого 6.7 сая төгрөгөөр, хөрөнгө борлуулсны орлого 0.3 сая төгрөгөөр, шууд бус орлого 3.1 сая төгрөгөөр, малд ногдуулах албан татварын орлого 1.5 сая төгрөгөөр, Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөрийн орлого 1.0 сая төгрөгөөр, Хог хаягдлын үйлчилгээний хураамжийн орлого 0.9 сая төгрөгөөр, ан амьтны нөөц ашигласны төлбөрийн орлого 1.1 сая төгрөгөөр, ус рашааны нөөц ашигласны төлбөрийн орлого 0.3 сая төгрөгөөр, нийт 22.3 сая төгрөгөөр тасарсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1."хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" гэсэн заалттай нийцэхгүй байна.

**Аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогын талаар:** Тайлант онд аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг 14.2 сая төгрөгөөр төлөвлөж 17.7 сая төгрөгөөр гүйцэтгэлийг хангуулж 3.5 сая төгрөг буюу 24.6 хувиар давуулан биелүүлсэн байна.

Хүснэгт № 5: Аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл /сая төгрөг/

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Аж ахуй нэгжийн орлогын албан татвар	3.2	-	-3.2	-
2	Авто тээврийн өөрөө явагч хэрэгслийн албан татвар	8.6	13.8	5.2	160.5
3	Зам ашигласны төлбөр	2.4	3.9	1.5	162.5
	<b>Нийт дүн</b>	<b>14.2</b>	<b>17.7</b>	<b>3.5</b>	<b>124.6</b>

Эх сурвалж: Чандмань-Өндөр төсвийн төвлөрүүлэн захирагчийн төсвийн гүйцэтгэлийн танилцуулга

Аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг нэр авч үзвэл Аж ахуй нэгжийн орлогын албан татварын орлогыг 3.2 сая төрлөөр тасалсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1."хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" гэсэн заалттай нийцэхгүй байна.

**Улсын төсөвт төвлөрүүлэх орлогын талаар:** Тайлант онд улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг 14.7 сая төгрөгөөр төлөвлөж 8.2 сая төгрөгөөр гүйцэтгэлийг хангуулж, 6.4 сая төгрөгөөр буюу 55.8 хувиар тасалсан байна.

Хүснэгт № 6: Улсын төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл /сая төгрөг/

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	4.9	5.1	0.2	104.1
2	Дотоод бараа үйлчилгээний НӨАТ	8.8	1.6	-7.2	18.2
3	Агаарын бохирдлын төлбөр	0.9	1.5	0.6	166.7
	<b>Нийт дүн</b>	<b>14.7</b>	<b>8.2</b>	<b>-6.4</b>	<b>55.8</b>

Эх сурвалж: Чандмань-Өндөр төсвийн төвлөрүүлэн захирагчийн төсвийн гүйцэтгэлийн танилцуулга.

Улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг нэр төрлөөр нь авч үзвэл Дотоод бараа үйлчилгээний НӨАТ-ын орлогыг 7.2 сая төгрөгөөр тасалсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1."хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" гэсэн заалттай нийцэхгүй байна.

#### Үйл ажиллагааны мөнгөн орлогын талаар

Тайлант онд үйл ажиллагааны орлогыг 1,328.0 сая төгрөгөөр төлөвлөж, 1,253.1 сая төгрөгөөр гүйцэтгэлийг хангуулж 94.4 хувийн гүйцэтгэлтэй байна. Үүнээс: Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн хүү болон эргэн төлөлтөөс 52.5 сая төгрөгийн орлогыг оруулахаар төлөвлөж гүйцэтгэлээр 53.2 сая төгрөгийн хүүгийн төлбөр болон зээлийн эргэн төлөлтийн орлогыг төвлөрүүлсэн байна.

#### Төсвийн зарлагын талаар:

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 8 хөтөлбөрт зориулан 1,327.9 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 859.5 сая төгрөгийг бараа ажил үйлчилгээний зардалд, 358.9 сая төгрөгийг урсгал шилжүүлгийн зардалд, 109.5 сая төгрөгийг эргэж төлөгдөх төлбөрийг хаасан цэвэр зээлийн зардалд зарцуулахаар төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр бараа ажил үйлчилгээний зардалд 792.8 сая төгрөгийг, урсгал шилжүүлгийн зардалд 280.3 сая төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,073.1 сая төгрөг буюу 80.8 хувьтай байгаа нь бараа ажил үйлчилгээний зардал 66.7 сая төгрөгөөр, урсгал шилжүүлгийн зардал 78.7 сая төгрөгөөр тус тус хэмнэгдсэн нь нөлөөлсөн байна. Төсвийн хэмнэлтийг харуулбал дараах байдалтай байна. Үүнд:

- Цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардал 15.3 сая төгрөг
- Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 9.2 сая төгрөг
- Байр ашиглалттай холбоотой зардал 2.1 сая төгрөг
- Эд хогшил урсгал засварын зардал 6.0 сая төгрөг
- Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамж 12.4 сая төгрөг
- Бараа үйлчилгээний бусад зардал 21.6 сая төгрөг
- Урсгал шилжүүлгийн зардал 78.7 сая төгрөгөөр тус тус хэмнэгдсэн байна.

ОНХС-ийн эх үүсвэрээр хэрэгжүүлэх 26 төсөл арга хэмжээнд 320.3 сая төгрөг баталснаас 19 төсөл арга хэмжээнд 241.6 сая төгрөгийг зарцуулж 78.7 сая төгрөгийн 7 төсөл арга хэмжээ хэрэгжээгүй байна. Төсөл арга хэмжээнүүд хэрэгжээгүй шалтгаан нь зураг төсөв байхгүйгээс зам засварын ажил, хөцөө, гүүр барих, гэр цэцэрлэгийн тохижилтын ажлууд хийгдээгүй байна.

Сумын Засаг даргын хөтөлбөрийн хэрэгжилт 1,073.1 сая төгрөгийн гүйцэтгэлтэй буюу 80.8 хувьтай байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.6.3 Нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

ТТЗ-ийн харьяа байгууллагуудад дээд шатны төсөв захирагчаас 3.2 сая төгрөг, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд худгийн орлого 0.3 сая төгрөг, нийт 3.5 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Гүйцэтгэлээр мал тооллогын зардалд 2.9 сая төгрөгийг, хамтарсан багийн зардалд 0.3 сая төгрөгийг, тендерийн баримт материалын зардалд 0.2 сая төгрөг нийт 3.4 сая төгрөгийг зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн**

2022 онд гадаад, дотоодын эх үүсвэрээр ямар нэгэн төсөл хөтөлбөр хэрэгжээгүй байна.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Чандмань-Өндөр сумын ТТЗ-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Давааням гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Тэгшдэлгэр, дарга тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар нар хэрэгжүүлсэн.

Чандмань-Өндөр сумын ТТЗ-ийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төрийн аудитын газарт 2023 оны 03 дугаар сарын 01-ны өдрийн 3/27 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр өмнөх оны үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2.0 хувиар тогтоож сонгосон суурь үзүүлэлтээс тооцож 65.0 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 52.0 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлын түвшнийг тайлант оны үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүн 1,006.1 сая төгрөгийг сонгож 16.1 сая төгрөгөөр шинэчлэн тогтоолоо.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор ТТЗ-ийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд нийт 1.2 сая төгрөгийн зөрчил илэрсэн. Илэрсэн зөрчилд 1.2 сая төгрөгийн 2 төлбөрийн актыг тогтоосон байна.

ТТЗ-ийн нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитаар Төрийн хэмнэлтийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой горим сорилыг хэрэгжүүлсэн. Горим сорилыг хэрэгжүүлэхэд алдаа зөрчилтэй асуудал илрээгүй.

### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны дансны тухай хуулийн хэрэгжилтийг хянаж үзэхэд мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлж ажилласан бөгөөд алдаа зөрчилтэй асуудал илрээгүй.

#### **4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Тус байгууллагын худалдан авах ажиллагааны баримт материалыг хянаж үзэхэд алдаа зөрчилтэй асуудал илрээгүй. Худалдан авах ажиллагаанд харьцуулалтын аргыг ашиглан бага үнийн санал ирүүлсэн байгууллагуудтай гэрээ хийж бараа материалыг худалдан авсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Чандмань-Өндөр сумын ТТЗ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд завсрын аудит хийгээгүй болно.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн 34.6 сая төгрөгийн зөрчилд 5 зөвлөмжийг өгсөн байна.

Хүснэгт №7 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	-	-	-	-	-
Албан шаардлага	-	-	-	-	-
Зөвлөмж	5	34.6	5	34.6	100
Нийт дүн	5	34.6	5	34.6	100

/сая төгрөгөөр/

Өмнөх оны 34.6 сая төгрөгийн 5 зөвлөмжийг хэрэгжүүлэн ажилласан байна.

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарал хандуулах асуудал илрээгүй болно.

### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд сумын орон нутгийн ерөнхий орлого болон харьяа 6 төсвийн байгууллага, 2 тусгай сан нийт 8 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 4 байгууллагад дүгнэлт гаргаж, 4 байгууллага түүвэрт хамрагдсан байна. Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгсөн. Тайлант онд боловсролын, соёл, эрүүл мэндийн салбарын 4 байгууллага улсын төсөвт шилжсэн тул хаалтын тайлан гаргаж нэгтгэсэн байна

ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлан төсвийн гүйцэтгэлийн аудитаар нийт 282.9 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн. Аудитын явцад 161.8 сая төгрөгийн 1 алдааг залруулж, 121.1 сая төгрөгийн зөрчилд 4 зөвлөмжийг өгсөн.

#### Залруулсан алдааны талаар:

ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд ОНХС-аас шилжүүлсэн хөрөнгийг үнэ төлбөргүй гарсан үндсэн хөрөнгө, үнэ төлбөргүй гарсан бараа материал дансанд бүртгэж тайлагнасныг үнэ төлбөргүй шилжүүлсэн бараа материал дансанд бүртгэж залруулга хийсэн.

#### ТТЗ-ийн харьяа байгууллагуудын зөрчлийн талаар:

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар нийт 186.9 мянган төгрөгийн зөрчил илэрсэн байна. Илэрсэн зөрчилд 1.4 сая төгрөгийн 3 төлбөрийн акт тогтоож, 21.0 сая төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага өгч, 164.5 сая төгрөгийн зөрчилд 6 зөвлөмжийг өгсөн байна.

##### 5.1 Төлбөрийн акт

ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар төлбөрийн акт тогтоогүй болно.

##### 5.2 Албан шаардлага

Албан шаардлага хариуцлага тооцох санал хүргүүлээгүй болно.

##### 5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

## **1. Орлого бүрдүүлэлттэй холбоотой асуудал**

### **1.1. Илрүүлэлт:**

Орон нутгийн орлогыг нэр төрлөөр нь авч үзвэл: Үйл ажиллагааны орлого 6.4 сая төгрөгөөр, хөрөнгийн орлого 6.7 сая төгрөгөөр, хөрөнгө борлуулсны орлого 0.3 сая төгрөгөөр, шууд бус орлого 3.1 сая төгрөгөөр, малд ногдуулах албан татварын орлого 1.5 сая төгрөгөөр, Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөрийн орлого 1.0 сая төгрөгөөр, Хог хаягдлын үйлчилгээний хураамжийн орлого 0.9 сая төгрөгөөр, ан амьтны нөөц ашигласны төлбөрийн орлого 1.1 сая төгрөгөөр, ус рашааны нөөц ашигласны төлбөрийн орлого 0.3 сая төгрөгөөр, нийт 22.3 сая төгрөгөөр тасалсан. Аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг нэр авч үзвэл Аж ахуй нэгжийн орлогын албан татварын орлогыг 3.2 сая төрлөөр тасалсан. Улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг нэр төрлөөр нь авч үзвэл Дотоод бараа үйлчилгээний НӨАТ-ын орлогыг 7.2 сая төгрөгөөр тасалсан байна. Орлогыг нэр төрлөөр нь нийт 32.7 сая төгрөгөөр тасалсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1."хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" гэсэн заалттай нийцэхгүй байгаа бөгөөд "Эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### **1.2. Өгсөн зөвлөмж:**

Улс, орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг нэр төрлөөр нь жигд ханган биелүүлж ажиллах.

## **2. Хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлттэй холбоотой асуудлын талаар**

### **2.1. Илрүүлэлт:**

Хоршоо хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлтэй 20 иргэнтэй холбоотой 88.4 сая төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байна. Энэ нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны 361 дүгээр тушаалаар баталсан "Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам"-ын 3.2.1."орон нутгийн жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх тэргүүлэх чиглэлийг жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ, хоршоо хөгжүүлэх бодлоготой уялдуулан тогтоож, хэрэгжилтийг зохион байгуулах, биелэлтэд нь хяналт тавих" гэсэн заалттай нийцэхгүй байна.

### **2.2. Өгсөн зөвлөмж:**

Хоршоо хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн зээлийн авлагыг бүрэн барагдуулж ажиллах.

## **3. ТТЗ-ийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд илэрсэн зөрчлийн талаар**

### **3.1. Илрүүлэлт:**

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 1.2 сая төгрөгийн зөрчил илэрсэн байна. Аудитаар 1.2 сая төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоосон байна.

### **3.2. Өгсөн зөвлөмж:**

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар тогтоосон төлбөрийн актуудыг тогтоосон хугацаанд нь биелэлтийг хангуулж ажиллах.

## **4. Дотоод хяналттай холбоотой асуудал**

### **4.1. Илрүүлэлт:**

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн орон тооны бус дотоод хяналтын нэгж нь харьяа байгууллагуудад хяналт шалгалтыг хийж илэрсэн алдаа зөрчилд зөвлөмж өгч ажилласан боловч хэрэгжилтийг үнэлж дүгнээгүй байна.

### **4.2. Өгсөн зөвлөмж:**

Алдаа зөрчлийг арилгах хугацаатай зөвлөмжийг өгч, хэрэгжилтийг тооцож ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 9 дүгээр сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Нягтлан бодох бүртгэлийн алдаа	1	161.8			1	161.8	1	161.8				
<b>Харьяа байгууллагын алдаа</b>												
ЗДТГ	1	205.6			1	205.6	1	205.6				
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>367.4</b>			<b>2</b>	<b>367.4</b>	<b>2</b>	<b>367.4</b>				

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой	4	121.1					4	121.1				
<b>Дүн</b>	<b>4</b>	<b>121.1</b>					<b>4</b>	<b>121.1</b>				
<b>Харьяа байгууллагуудын зөрчил</b>												
Чандмань-Өндөр ЗДТГ	1	1.0	1	1.0								
Чандмань-Өндөр ИТХ	1	0.2	1	0.2								
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>1.2</b>	<b>2</b>	<b>1.2</b>								

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:  
 ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
 АНХАН ШАТАНД ХЯНАСАН:  
 АУДИТЫН МЕНЕЖЕР  
 БАТАЛГААЖУУЛСАН:  
 АХЛАХ АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР ОГНОО:

Б.ТЭГШДЭЛГЭР ОГНОО:

Б.ДАВААНЫМ ОГНОО: